

## ЛЕКЦ, ЯРИАНЫ СЭДЭВ

Л. Миеэбазар

**ЗЭВСЭГ ХУРААХ АСУУДЛААР ХЯТАДЫН  
БАРИМТАЛЖ БАЙГАА БОДЛОГО**

МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэлд: «Хятадын өнөөгийн эрх баригчид олон улсын империалист хүчинтэй нэгэн эгнээнд явж байна. Эдийн засаг, улс төрийн талаар шахан хавчиж, бусад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс бүдүүлгээр оролцож, цэрэг дайны аюул занал бий болгох, хөрш улсуудын эсрэг зэвсэгт халдлага үйлдэж, шинэ колониололыг өөгшүүлэн хөхүүлж, фашист болон арьсны өнгөөр ялгаварлагч дэглэмүүдийг дэмжиж байгаа энэ бүхэн нь бээжингийн эрх баригчдын бодлогын салшгүй шинж чанар боллоо.» гэж дүгнэсэн билээ.

Бээжингийн эрх баригчдын дэлхийд жанжлах харгис санаархлын тод томруун илрэл нь зэвсэг хураах асуудлаар тэдний баримталж байгаа чиг шугам, практик үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, хятадын удирдагчид зэвсэг хураах биш, харин зэвсэглэлийн хойноос хөөцөлдөж, цэрэг зэвсгийн хүчин чадлаа байнга өсгөн нэмэгдүүлэх замаар жанжлалын бодлогоо хэрэгжүүлэх стратегийн зорилго тавьж байна.

Иймээс ч тэд зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг хязгаарлах, зэвсэг хураах талаар бодит, үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа бүх оновчтой санал, санаачилга, хүчин чармайлтыг боож саатуулахыг оролдсоор байна.

Тэрхүү чиг бодлогоо зөвтгөх зорилгоор тэд зэвсэглэлээр хөөцөлдөх явдал даамжирч байгаагийн гол хариуцлагыг ЗХУ-д тохох, ЗХУ-ын бодлогыг мушгин гуйвуулж гүтгэхийг оролдож, өөрсдийгөө «гурав дахь ертөнц»-ийн орнуудын ашиг сонирхлыг хамгаалагч, «хэт их гүрнүүдийн» эсрэг тэмцэгч болгон дүрслэхийг хичээж байна.

60, 70-аад онд Хятадын удирдагчид зэвсэг хураахад чиглэсэн бүхий л алхмыг шууд илэрхий эсэргүүцэж, дэлхийн дайныг илэрхий сурталчилж, зэвсэг хураах хэлэлцээ ярианд оролцохоос эрс татгалзаж ирсэн бол сүүлийн үед арга тактикаа өөрчлөн дэлхийн шинэ дайныг «хойшлуулж» болох тухай ярих болсноос гадна зэвсэг хураах асуудлаар олон талын хэлэлцээ хийдэг байгууллага. Зэвсэг хураах хорооны (ЗХХ) үйл ажиллагаанд 1980 оноос оролцох боллоо.

Дайныг «хойшлуулж» болох тухай ярих болсны цаад учир нь цаг хожиж хятадын зэвсэгт хүчнийг шинэчлэж амжихад оршиж байгаа юм.

ЗХХ-ны ажилд оролцож эхэлсэн цагаасаа Хятад уг байгууллагын индрийг зөвлөлтийн эсрэг, социализмын гадаад бодлогын эсрэг гүтгэлэг хийхэд ашиглах, хорооны анхаарал, хүч чармайлтыг зэвсэг хураах асуудлыг нааштай хэлэлцэн шийдвэрлэх зорилтоос хөндийрүүлж, хэлэлцээг үр ашиггүй хоосон маргааны талбар болгохыг оролдсоор байна.

Зэвсэг хураах асуудлаар хэлэлцээ хийхэд баримтлах ёстой гол үндсэн зарчим адил тэгш байх, адил тэгш аюулгүй байдлын зарчмыг Хятадын эрх баригчид ор тас үгүйсгэж, зэр зэвсгийн тоо хэмжээгээр бус-

даас үлэмж давуу «хоёр хэт их гүрэн» эхэлж зэвсгээ хорогдуулах ёстой гэдэг «зарчмыг» улиглан давтсаар ирлээ.

БНХАУ цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлах, цөмийн зэвсгийг хураах асуудалд чухамхүү ийм байр сууриас хандаж байгаа юм. Бээжингийнхнээр бол «хоёр хэт их гүрэн» (ЗХУ, АНУ-ыг хэлж байна) цөмийн зэвсгийнхээ тоо хэмжээ, хүчин чадлыг Хятадын цөмийн зэвсгийн хүчин чадлын хэмжээнд хүртэл хорогдуулсны дараа л сая зэвсэг хураах асуудлыг авч үзэж болох ажээ. Энэ бол уг чанартаа ЗХУ, социалист бусад орон, энхийг эрхэмлэгч бүх улс түмний аюулгүй байдлын эрх ашгийг хөсөр хаяж, эдүгээ нэгэнт бий болсон хүчний тэнцүү харьцааг алдагдуулах нэн аюултай чиг бодлого юм.

Цөмийн зэвсгийг агаар мандал, сансрын уудам, усан дор туршихыг хориглох тухай Москвагийн 1963 оны Гэрээнд БНХАУ одоо хүртэл нэгдэж ороогүйгээр барахгүй түүнийг зөрчиж цөмийн зэвсгийг агаар мандалд туршиж байгаа цорын ганц улс болж 1964-1980 онд тийм туршилтыг 22 удаа хийлээ. БНХАУ цөмийн зэвсгээ тоо, чанарын талаар өсгөн нэмэгдүүлэхийг сонирхож байгаа учраас цөмийн зэвсгийн туршилтыг бүх нийтээр бүрэн хориглох асуудлыг хэлэлцэж, холбогдох гэрээ байгуулахад чиглэсэн социалист орнуудын тодорхой санал, хүчин чармайлтыг АНУ, Англи зэрэг өрнөдийн гүрний хамт эсэргүүцэн саатуулсаар байна.

Хятадын эрх баригчид зэвсэглэлээр хөөцөлдөх бодлогоо чөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд зэвсэг хураах талаар байгуулагдсан олон улсын чухал чухал гэрээ хэлэлцээрт огтхон ч оролцдоггүй юм. Тухайлбал, 1968 онд байгуулсан цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээг түгээмэл болгон, цаашид улам бэхжүүлэх явдал олон улсын байдал хурцдаж, цөмийн дайны аюул ихэссэн өнөөгийн нөхцөлд чухал ач холбогдолтой байтал Хятад уг гэрээнд нэгдэн орохгүй байгаагаар үл барам, гэрээг өөлөн шүүмжлэгчдийг дэвэргэж, «хоёр хэт их гүрэн» цөмийн зэвсгээр өрсөлдөж байгаа үед бусад улс орон аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор уг зэвсгийг эзэмших эрхийг хасч хязгаарлаж болохгүй гэж махран зүтгэсээр байна.

Тэр ч байтугай химийн зэвсгийг бүрэн хориглож устгах асуудлаар хятадууд өрнөдийн орнуудын байр суурийг дэмжиж, Афганистан, Лаос, Кампучит ЗХУ-ыг химийн зэвсэг хэрэглэж байгаа мэтээр гүтгэсээр байна.

Түүнчлэн хятад химийн зэвсгийг хориглож устгах гэрээнд уг зэвсгийг зөвхөн хэрэглэхийг хориглосон заалт оруулах гэж эрмэлзэж байгаа нь Женевийн 1925 оны гэрээний ач холбогдлыг бууруулах, цаашлаад бүр үгүйсгэхэд чиглэсэн хортой санаа юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXVI чуулганд цөмийн сүйрлийг сэрэмжлэн зайлуулах тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тунхаглал батлах, сансрын уудамд аливаа төрлийн зэвсэг байрлуулахыг хориглох тухай ЗХУ-аас оруулж хэлэлцүүлсэн нэн чухал саналуудыг Хятад эсэргүүцэж уг асуудлаар Ерөнхий Ассамблейгаас баталсан хоёр тогтоолыг дэмжээгүй юм. Цөмийн сүйрлийг сэрэмжлэн зайлуулах тухай саналын гол үндэс-цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй байх тухай заалтыг Хятадын төлөөлөгч мугуйдаар мушгин гуйвуулж. «ЗХУ ердийн зэвсгийнхээ нөөц, чадлын давуутай талыг ашиглаж хүчээр түрээ барих зорилгоор дээрх саналыг дэвшүүлж байна» гэж гүтгэн дайрсан юм.

Эдгээр баримт нь Хятадын өнөөгийн эрх баригчид зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, зэвсэг хураахын төлөө улс гүмний хүчин чармайлт, хүсэл шаардлагыг хэрхэн яаж жадлан эсэргүүцэж байгааг нотлон харуулж байна.

Гадаадын хэвлэлийн мэдээнээс үзэхэд одоо БНХАУ зэвсэгт хүчний бүрэлдэхүүний тоогоор (4,5 сая шахам хүнтэй) дэлхийд тэргүүн байр эзэлж байна. Пуужинт цэргийн хүчийг 1960-аад оноос бий болгосон бөгөөд одоо пуужин харвах суурь 150 орчим, 20-200 килотоннын хүчтэй цөмийн цэнэг зөөх нисэх пуужингуудтай болжээ. Тухайлбал, 3000 км зайд нисэх CSS-2 гэдэг пуужин 60 орчим, дунд зайны (1100 км орчим) CSS-1 гэдэг пуужин 50 орчим байгаа ажээ. 1980 оны тавдугаар сард Хятад тив алгасан нисэх (13000 км орчим) CSS-4 гэдэг пуужин туршиж түүнийгээ «дөрвөн шинэчлэлийн төлөвлөгөөг хурдасгахад нэн их ач холбогдолтой» аугаа их ялалт гэж магтаж байв.

БНХАУ цөмийн зэвсэг зөөх Хонг-6 хэмээх 60 орчим бөмбөгдөгч онгоцтойгоос гадна атомын хөдөлгүүртэй усанд шумбагч онгоцтой болжээ.

Цэрэг зэвсгийн хүч чадлыг шинэчлэн нэмэгдүүлэхэд БНХАУ асар их хөрөнгө, улсын төсвийн 40 гаруй хувийг зориулж байна.

Бээжингийн жанжлах бодлоготнууд ийнхүү зэвсэг хураах үйл явцад саад хийж, зэвсэглэлийн хойноос хөөцөлдөхийн зэрэгцээ цэрэг-стратегийн хүчний хувьд социалист ертөнцөөс давуутай болохыг оролдож байгаа америкийн империалист бүлгийнхний практик үйл ажиллагааг илт өөгшүүлэн дэмжиж улмаар тэднийг ЗХУ-тай мөргөлдүүлэх бодлого явуулж байна. Үүнтэй холбогдуулан «Олон улсын нөхцөл байдлыг цаашид хурцатгах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг дэвэргэх, улсуудын хоорондын хэвийн харилцааг эвдэх чиг бодлого нэг ч ард түмэнд сайн юм өгөхгүй» гэж Л. И Бреяшев ЗСБНХУ-ын үйлдвэрчний эвлэлийн XVII их хурал дээр саяхан цохон тэмдэглэснийг онцлон дурдах хэрэгтэй юм.

Өрнөд Европт америкийн дунд зайны тусгалтай пуужинт цөмийн шинэ зэвсэг байрлуулах тухай НАТО-гийн Зөвлөлийн 1979 оны арван хоёрдугаар сарын 12-ны шийдвэрийг хятадын суртал ухуулга ЗХУ-ын «цэргийн аюулыг сөрж НАТО-гийн орнуудаас батлан хамгаалах хүчээ бэхжүүлэх чухал алхам» гэж илэрхий сайшааж байна.

Хятадын эрх баригчид АНУ болон өрнөдийн бусад орноос цэргийн зэвсэг техник худалдан авахыг онцгой олзуурхаж байгааг империалист харгис хүч талархан дэмжиж байна. АНУ Хятадад байлдааны нисдэг тэрэг, ачааны «С-130» нисэх онгоц, алсын холбооны аппарат хэрэгсэл, тийрэлтэт хөдөлгүүр турших тоног төхөөрөмж зэрэг хос зориу- лалт бүхий техник нийлүүлэхэд бэлэн байгаагаа Пентагон зарласан юм.

Өрнөдийн хэвлэлийн мэдээгээр 1981 оны тавдугаар сард Рейганы засаг захиргаа Хятадын хүссэн 52 нэр төрлийн цэргийн техникийн 30-ыг, тэдгээрийн дотор «Хок» хэмээх зенитийн пуужин танк эсэргүүцэх пуужин, хуягт тэрэг зэргийг худалдахыг зөвшөөрчээ.

Энэ бүхнээс үзэхэд Хятадын эрх баригчдаас зэвсэг хураах асуудлаар баримталж байгаа бодлого нь зэвсэг хураах биш, харин зэвсэглэх бодлого мөн болохыг дахин батлаж байна.